



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 3/29/26

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дүрмийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-ийн Удирдах зөвлөлийн дэргэдэх гүйцэтгэх хорооны ажиллах журмыг хавсралт зооор баталсугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



О.МӨНХНАСАН



“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ГҮЙЦЭТГЭХ ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмыг “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” Нийтийн эрх зүйн хуулийн этгээд (цаашид НЭЗХЭ гэх)-ийн дүрмийн 21 дүгээр зүйлийн 21.8 дахь заалтад үндэслэн боловсруулж батлав.
- 1.2 Энэхүү журмын зорилго нь “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-ийн дүрэмд заасан удирдах зөвлөлийн дэргэдэх гүйцэтгэх хорооны үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН БА ЧИГ ҮҮРЭГ

- 2.1 Гүйцэтгэх хорооны бүрэлдэхүүн нь Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн дарга, Дэд ерөнхийлөгч гэсэн албан тушаалтнаас бүрдэнэ.
- 2.2 Гүйцэтгэх хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
 - 2.2.1 Удирдах зөвлөлийн хурлын тогтоолоор тухайлан даалгасан асуудлаар шийдвэр гаргах,
 - 2.2.2 Тухайн жилийн ажлын албаны төсөв болон төрийн зарим чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны төсвийг хэлэлцэж, удирдах зөвлөлийн хуралд шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх,
 - 2.2.3 Гүйцэтгэх захиралд 50 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гэрээ байгуулах эрхийг тухайн гэрээ тус бүр дээр олгох,
 - 2.2.4 Урьдчилан мэдэх боломжгүй эсхүл гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулах нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар худалдан авах ажиллагааны журамд заасан хугацаа, шаардлагыг баримтлахгүй гэрээ байгуулах эрхийг гүйцэтгэх захиралд олгох,
- 2.3 Гүйцэтгэх хороо нь гаргасан шийдвэр бүрийг дараагийн Удирдах зөвлөлийн хуралд танилцуулна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ ХОРООНЫ ХУРАЛ, ШИЙДВЭР

- 3.1 Гүйцэтгэх хорооны хуралд бүрэлдэхүүний дийлэнх олонх (2/3) албан тушаалтан оролцсоноор тухайн хурал хүчинтэйд тооцогдоно. Хурлыг ерөнхийлөгч эсхүл ерөнхийлөгчийн даалгаснаар Удирдах зөвлөлийн дарга даргална.
- 3.2 Гүйцэтгэх хорооны хурал цахим эсхүл танхим хэлбэрээр зохион байгуулагдана. Цахим хэлбэрээр зохион байгуулах тохиолдолд хуралд оролцож буй албан тушаалтнууд өөрийн нэрийг хэлж санал, асуултаа тавина.
- 3.3 Гүйцэтгэх хороогоор хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон албан тушаалтнуудын дийлэнх олонх (2/3)-ын саналаар батлагдсан тооцно. Албан тушаалтан бүр 1 саналын эрхтэй оролцоно. Санал тэнцсэн тохиолдолд Ерөнхийлөгч шийдвэрлэх санал өгнө.

- 3.4 Гүйцэтгэх хорооны шийдвэр тогтоол хэлбэртэй байна. Тогтоолд ерөнхийлөгч гарын үсэг зурж баталгаажуулна. Тогтоол батлагдсан даруйдаа хүчин төгөлдөр болно.
- 3.5 Гүйцэтгэх хорооны хурлыг Ерөнхийлөгч эсхүл Ерөнхийлөгчийн даалгаснаар Удирдах зөвлөлийн дарга зарлан төвлөнө. Хурлаар хэлэлцэх материалыг албан тушаалтнуудад урьдчилан 1 өдрийн өмнө хүргүүлнэ. Яаралтай хурал хуралдах тохиолдолд урьдчилан материал хүргүүлэхгүй байж болно.
- 3.6 Гүйцэтгэх хорооны нарийн бичгээр Удирдах зөвлөлийн нарийн бичиг ажиллана. Яаралтай хурал хуралдах тохиолдолд хурлын тэмдэглэлийг хурал даргалагч дуу хураагуур ашиглан тэмдэглэн авч нарийн бичигт хүлээлгэн өгнө.
- 3.7 Гүйцэтгэх хорооны нарийн бичиг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
 - 3.7.1 Гүйцэтгэх хорооны хурлын тэмдэглэлийг хөтлөх,
 - 3.7.2 Гүйцэтгэх хорооны хурлаас гарах тогтоолын төслийг бэлтгэх, албажуулах ажлыг зохион байгуулах,
 - 3.7.3 Гүйцэтгэх хорооны хурлаар хэлэлцэх асуудлын материалыг хуралд хэлэлцэх асуудал оруулсан этгээдээс гаргуулж, албан тушаалтнуудад хүргүүлэх,

ДӨРӨВ. БУСАД ЗҮЙЛ

- 4.1 Энэхүү журмыг 2026 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар баталж, батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

--ooOoo--